

## ТЭВШИЙН БИЧЭСИЙГ ДАХИН НЯГТЛАХ НЬ

Ц.БАТТУЛГА

МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Түрэг судлалын тэнхим  
ts\_battulga@yahoo.com

Түлхүүр үг: Монголын руни, Тэвшийн бичээс

**ӨГҮҮЛЛИЙН ТОВЧ:** ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн олдворын сан хөмрөгт хадгалагдаж байгаа Тэвшийн бичээсийг дахин нягтлан судалсан болно. Эл бичээсийн хоёрдугаар мөр омнох эрдэмтдийн судалгаанд төдий л бүрэн хэмжээгээр тусгагдаагүй байдаг тул судалгааны эргэлтэд оруулахыг хичээллээ.

Судалгааны ном зохиолд “Тэвшийн түрэг бичээс” гэж нэрлэгдсэн, багахан чулуун дээрхи бичээсийг анх 1949 онд Оросын эрдэмтэн А.Н.Окладниковын удирдсан хээрийн шинжилгээний анги олж илрүүлжээ. Б.Ринчен академич 1968 онд бүтээлдээ гэрэл зургийг нь хэвлүүлснээр (Rintchen, 1968) эл бичээсийн талаархи анхны бодит мэдээ шинжлэх ухааны эргэлтэд орсон байна. Археологич Н.Сэр-Оджав уг бичигт чулууг Улаанбаатар хотод авчирсан бөгөөд эдүгээ ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн олдворын сан хөмрөгт хадгалагдаж байгаа билээ.

Н.Сэр-Оджав гуай Тэвшийн бичээсийн анх байсан газрынх нь тухай “Өвөрхангай аймгийн Богд (хуучнаар Ховд) сумын төвөөс 20 орчим км-ын зайд орших Тэвш гэдэг баруун зүүн тийш хөндөлдсөн хавтгай нурууны өвөрт байсан” (Сэр-Оджав, 1977) гэж тэмдэглэжээ. Тэвшийн бичээс хэмээн нэрлэгдсэн энэ дурсгал нь хоёр мөр бичээс, нэг тамганаас бүрдэх ба 54 x 42 см хэмжээтэй бор хүрэн өнгөтэй чулуунаа сийлэгджээ.

Уг бичээсийн нэгдүгээр мөр 32 см, хоёрдугаар мөр 14 см орчим урт, тамганы өндөр 16 см, өргөн нь 16,5 см юм. Нэгдүгээр мөр бичээс 23, хоёрдугаар мөр бичээс 10 үсэг тэмдэгтээс бүрдэж байна. Хадны зурагт нийтлэг тохиолдох хонхойлгон цохиж цоолборлох аргаар зурсан, хүний зураг байх бөгөөд 13,5 см өндөр, 7 см өргөн юм.

Тэвшийн бичээс олон жилийн турш ШУА-ийн Түүхийн хүрээлэн, эдүгээ Археологийн хүрээлэнгийн олдворын сан хөмрөгт хадгалагдаж байгаа хэдий ч төдий л сайн судлагдаагүй нь зураасан бичигтэй, үсэг тэмдэгт бүдгэрч

харагдахуйяа бэрх болсон, хэмжээний хувьд бага зэргээс шалтгаалсан бололтой.

Анх түрэг судлаач В.М.Наделяев 1974 онд уул бичээсийн зөвхөн эхний мөрийг “Түгчүү бургучы Ягыз-чурын тамга” гэж уншаад орос орчуулгын хамт хэвлүүлжээ. Тэрбээр уг чулуунаа бүхүй тамгыг Ягызчурын овгийн тамга гэж үзсэн байна (Наделяев,1974).

Хоёрдугаар мөрийн бичээс маш нарийхан сийлэгдсэнээс гадна олон жилийн нар салхинд идэгдэн ихэд бүдгэрсэн тул тодруулах, томруулах багажийн тусламжтайгаар үзэж уншихаас өөр аргагүй юм. Тийм ч учраас энэ мөрийг тэр бүр судалсангүй, орхигдуулсаар иржээ.

С.Харжаубай 1979 онд уул дурсгалыг дахин судлан нийтлүүлэхдээ хоёрдугаар мөрийн бичээсийг анх удаа галиглан орчуулсан байна (Харжаубай,1979). Гэхдээ нэгдүгээр мөрийн зарим нэгэн үсэг тэмдэгтийг буруу ташаа буулгасан, хоёрдугаар мөрийн зарим үсэг тэмдэгтийг орхисон зэргээс үүдэн уншлага, орчуулга ташаа мадагтай болсон ажээ.

Тэрбээр бичээсийг

- 1.Tuγčim urayači Yaγiz- čur tuγ ötü
2. tuγči bu...гэж үгчлэн галиглаад монгол хэлнээ
  1. хэнгэрэгч минь, уриач /дуудагч/ Ягыз-чур хэнгэргээ дуугарган /хангинуулан/....
  2. Хэнгэрэгч энэ... хэмээн орчуулсан аж.

С.Харжаубайн судалгаанаас үзвэл бичээсийн нэгдүгээр мөрийн tuγči хэмээх үгнээ “m” нэмж buraγači гэх үгийг urayači гэж уншсан байна. Түүнчлэн tuγraγi хэмээхийг tuγ ötü гэж илтэд ташаа буулгажээ (Харжаубай, 1979).

Дурсгалын эх бичээсийг үзэхэд цагаан өнгийн бэх(?) -ээр “ї ” үсгийг “γ ” үсэг тэмдэгттэй хамтатган нийлүүлж зураад “и ” болгосон нь илэрхий байх юм.

Л.Болд доктор 1990 онд хэвлүүлсэн бүтээлдээ С.Харжаубайн судалгааг дурдаад В.М.Наделяевын уншлагыг монгол хэлнээ орчуулан нийтлүүлсэн бөгөөд (Болд,1990) “Орхон бичгийн дурсгалууд II” бүтээлдээ мөн судалгааны галигийг хэвээр нь авч монгол хэлнээ орчуулсан авч хоёрдугаар мөрийн талаар юу ч дурдсангүй ажээ (Болд, 2000).

Л.Болд гуай бичээсийг “tuγči buraγi γ yaγiz čur tuγraγi” гэж галиглан “түгч, бүрээч Ягыз-чур (хаан)-ы тамга” хэмээн монгол хэлнээ орчуулжээ.

Тэвшийн бичээсийн дээр дурдсан мэт уншлага судалгааны зарим алдаа мадгийг залтуулах, хоёрдугаар мөрийг гүйцэт уншиж тайлах зорилгоор бид дахин няглан судласан юм. Судалгааны үр дүнг толилуулбал;

**Эх бичээс;**

МИЧИГАЧУЛЧИДЫЛЧИГАДАЛЬЧИГА 1

[M]x|d|g|d|t|l|v|g| 2

**Үсгийн галиг;**

1. TWGčiBWWRGčiYGrčWRTWGRGi

2. TWGčiBWBašsd [ti]

**Үгийн галиг;**

1. tuγči buriγči yaγiž čur tuγraγi

2. tuγči bu baš esid [ ti]

**Орчуулга;**

1. Тугч бүрээч Ягыз чурын дохио [тамга?] нь

2. Тугч үүнийг эхлэн сонсго [лоо]

**Тайлбар**

ТАЛЬЧА tuγči -Мэргэжлийн нэр үүсгэх"-чи, -чи" энэ дагавар монгол түрэг хэлэнд нийтлэг тохиолдох бүтээлч дагавар юм.

МИЧИГА tuγraγi - Бичээсийн нэгдүгээр мөрийн хувьд В.М.Наделяевын уншлагатай санал нэг боловч "tuγraγ-i" гэх үгийн тухайд "тамга" бус "дохио" гэж орчуулах нь зохистой мэт. Эртний түрэг хэлний тольд уг үгийг "хааны тамга" (ДТС,1969) гэсэн утгатайг тэмдэглэжээ. Гэвч логикийн үүднээс авч үзэхэд "дохио" гэж орчуулбал бичээсийн утгад илүү нийцэх мэт санагдана.

Хэрэвзээ тийн ухах аваас "tuγraγ" хэмээх үг монгол хэлний чиин-цуу, чиурчай-цуурай, чиургал-цуурхал, чиүг, чиүг-цуур, чиурчин-цуурчин, tuγrai-туурай хэмээх үгс язгуур гарал нэг байж болох талтай (Баттулга , 2005).

ТАЛЧА buriγči – Бүрээч. Уйгур "baγu" буюу эвэр бүрээг "bogya", зөрчинөөр "buran" гэж хэлдэг байна (Сесенчоγи,1988).

▷baš- тэмдэгт үсэг Туньюкукийн гэрэлт хөшөөний нэгдүгээр хөшөөний бичээсийн 26-р мөрд, Дарвийн бичээсэд ▷baš хэлбэрээр (Шинэхүү,1972).

Енисейн дурсгал, тухайлбал Уюк-Арханы нэгдүгээр бичээсэд "är atüm yaš aq ~~bäš~~ bän" (Малов, 1952) гэх зэргээр тохиолдоно.

Эдгээр жишээ баримт ~~и~~ үсэг тэмдэгтийг нэг үг буюу "baš-tolgoi" хэмэн унших бүрэн үндэстэйг харуулна.

Ягыз чур цолт нэгэн туг барьж бүрээ үлээдэг албатай байснаас "туч, бүрээч" гэж олноо алдаршсан байж болох юм. Чур цол нь түүний эрэлхэг, зоригтой, баатар нэгэн болохыг давхар гэрчилж байна.

### ҮГИЙН ТОЛЬ

Түүх түүх - ~~и~~ түүх ; түгч

Түүрийн түүх - ~~и~~ bürüyeci- ~~и~~ bürüyecii бүрээч

Чийд ягыз- ~~и~~ ягыз Ягыз (хүний нэр)

Чур чур - ~~и~~ чур~чор чур /цол/

Дохио, тэмдэг, тамга  
тамга

ї- хамаатуулах нөхцөл

Энэ бы - ~~и~~ ене, энэ

~~и~~ baš- ~~и~~ tolüai . . . . . 1. tolüai, terigün, türögüü; 2. eki, terigülen;  
1. Толгой, тэргүүн, түрүү; 2. эхлэн, түрүүлэн

[M]x| esid | ti]

esid - ~~и~~ sonus

e.- ti- sonus [-qaluγ-a] сонсго [лоо]

### НОМ ЗҮЙ

Баттулга Ц. 2005, Ханангийн бууцны бичээс, Studia Archaeologica, Том XII, fasc.3.  
Улаанбаатар, тал.82-86.

Болд Л. 1990 , БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс. Улаанбаатар, тал.110-112.

Болд Л. 2000, Орхон бичгийн дурсгал II. Улаанбаатар, тал.237-241.

ДТС. 1969, Древнетюркский словарь, Ленинград, 1969, стр.584.

Малов С.Е. 1952, Енисейская письменность тюрков. Москва-Ленинград, стр. 13.

Наделяев М.Н., 1974, Древнетюркская надпись из Ховд сомона МНР, Бронзовой и железный век Сибирии. Ленинград, стр.136-150.

Сэр-Оджав Н. 1977, Монголын эртний түүх. Улаанбаатар, тал.141.

Харжаубай С. 1979. Эртний гурван бичээс, -Studia Archaeologica. Tom.YII, Fasc.10-18.  
Улаанбаатар, тал.32-35.

Шинэхүү М. 1972, Даривын эртний түрэг бичээс, Монголын эртний түүх-соёлын зарим асуудал. Том.Y, Fasc.10, Улаанбаатар, тал.141.

Сэцэнцогту, 1988, Mongol üges-ün ijayur-un toli, jing jia keu, 819 düber tal-a.

Rintchen, 1968 . Les dessings pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie, -Corpus Scriptorum Mongolorum, Tom. XVI, fasc. I, Oulanbator.

SUMMARY

Ts. Battulga

TEVSH INSCRIPTION

This script is kept in the collection of the Institute of Archeology, Mongolian Academy of Sciences.

*Text*

ئىچىچەپلىخانىمىزلىپەرىدىلىخان 1

[ئى]خىلەتلىخان 2

*Transliteration*

1. T W G č i B W R G č i Y G z č W R T W G R G i
2. T W G č i B W Baš s d [ti]

*Transcription*

1. tuγči buryuči yaγiz čur tuyrayi
2. tuγči bu baš esid [ ti]

*Translation of the text*

1. The signal [seal ?] of Yagiz Chur, a standart-bearer and trumpeter
2. The standart-bearer announce (ed) it at first.